

ТАНИЛЦУУЛГА

Төрөөс ойн талаар баримтлах бодлогын зорилтыг хангах, хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулж буй ажил, бодлого, зохицуулалтын тухай

2017- 04 - 28.


Төрөөс ойн талаар баримтлах бодлогын баримт бичгийг УИХ-ын 2015 оны 49 дүгээр тогтоолоор баталсан. Энэхүү бодлогын зорилго, зорилтыг хангах зорилгоор Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэг, Төрөөс ойн талаар баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын 2015 оны 49 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/98 дугаар тушаалаар Төрөөс ойн талаар баримтлах бодлогын зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний дунд хугацаа (2017-2021 он) - ны төлөвлөгөөг боловсруулж, батлан гаргалаа. Тус төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулан улсын төсөв, зээл, тусламжид хамруулан ойн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх менежментийн зөв тогтолцоо, удирдлагын оновчтой бүтцийг бий болгох зэрэг арга хэмжээ авч ажиллах нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамны үндсэн үүрэг болж байна. Төрөөс ойн талаар баримтлах бодлогын үндсэн зорилтуудын хүрээнд манай яамнаас дараах ажлуудыг зохион байгуулж, бодлого, зохицуулалтаар ханган ажиллаж ирлээ. Үүнд:

1. Ойг түймэр, өвчин, хортноос хамгаалах, хууль бус мод бэлтгэлийг таслан зогсоох менежмент, чадавхийг бий болгон ойг хомсдол, доройтлоос сэргийлэх:

1.1. Ой, хээрийн түймэр. 2016 оны ой, хээрийн түймрийн мэдээллийг 2015 онтой харьцуулахад улсын хэмжээнд гарсан ой, хээрийн түймрийн нийт тоо 53.5%, ойн түймэрт шатсан талбай 55.2%, хээрийн түймэрт шатсан талбай 49.8%, түймэр гарсан сумын тоо 53.4%-иар тус тус буурсан.

Зураг 1.

2015-2016 оны ой, хээрийн түймэрт шатсан талбайн хэмжээ, /мян.га/



Улсын хил дамнан орж ирсэн ой, хээрийн түймэр ОХУ-аас 2015 онд-11, 2016 онд-5, БНХАУ-аас 2015 онд-2 удаа тус тус бүртгэгджээ. 2015-2016 онд Улсын хэмжээнд гарсан ой, хээрийн түймрийн товч мэдээллийг (Хүснэгт 1) нэгтгэн харуулав.

Ой, хээрийн түймрийн мэдээ, 2015-2016 он

№	Түймрийн мэдээ		Хэмжих нэгж	2015он	2016 он
1	Түймэр гарсан	аймаг	тоо	16	14
		сум	тоо	114	61
2	Гарсан түймрийн тоо		тоо	354	138
3	Бүгд шатсан талбай		мян. га	5847.9	2900.0
4	Үүнээс:	ой	мян. га	31	17.1
		хээр	мян. га	5816.9	4700.0
5	Нийт хохирол		сая төг	6270,0	8649.9
6	Үүнээс:	Экологийн	сая төг	5940,0	8100,0

*Эх үүсвэр: ОБЕГ-ын мэдээллээр

Ус, цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс 2016 онд хиймэл дагуулын мэдээгээр улсын хэмжээнд 15 аймгийн 34 суманд 98 удаагийн ой, хээрийн түймрийг урьдчилан илрүүлж, холбогдох газруудад мэдээллэж ажиллав.

Зураг 2.

Улсын хэмжээнд гарсан ой, хээрийн түймрийн тархалт 2015-2016 он



Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 2015-2016 онд түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Үүнд:

1. Ойг түймрээс хамгаалах тухай Монгол улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн ажлын хэсгийн 4-р уулзалтыг Улаанбаатар хотод амжилттай зохион байгуулав.

2. “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах үйл ажиллагааг зохицуулах Үндэсний болон түймрийн эрсдэл ихтэй аймаг, сумуудад Орон нутгийн зөвлөлийг байгуулан ажиллав.

3. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, унтраах ажлын шуурхай байдлыг хангах, мэдээлэх, Талуудын оролцоог зохицуулах үүрэг бүхий шуурхай зохицуулалтын жижүүрийг 2015-2016 оны хавар, намрын түймрийн аюултай улирлын хугацаанд ажиллуулав.

4. Түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах зориулалтын 4 нэр төрлийн багаж, хэрэгслээр түймрийн эрсдлийн бүсэд багтах зарим аймгийн БОАЖГ, сум дундын ойн анги, УТХГ-ыг хангах ажлыг зохион байгуулав.

5. ОХУ-тай хиллэх Улсын хилийн дагуу 2014-2016 онд 10-20 м өргөн, 30-40 см гүн, 600 гаруй км урт шороон болон халз зурвас байгуулах ажлыг улсын болон орон нутгийн төсвөөр зохион байгуулж, Хил хамгаалах ерөнхий газартай 2017-2020 онд хамтран ажиллах “Санамж бичиг” байгуулав.

6. Сансрын хиймэл дагуулын мэдээгээр авсан түймрийн голомт, тархалтын зураг, хуурайшилтын мэдээ, мэдээллээр хэрэглэгч байгууллагуудад үйлчилж, түймрийн аюултай улиралд үүлэнд зориудаар нөлөөлөх ажлыг зохион байгуулав.

7. “Түймрийн тархалтаас сэргийлэх халз зурвас, шороон зурвас. Чанарын ерөнхий шалгуур, үнэлгээ” MNS 6530:2015 стандартыг тус тус батлуулж, хэрэгжүүлж эхлэв.

Ой, хээрийн түймрийн эрсдлийн бүсэд байрлах аймгуудын түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах Зөвлөл болон Ойн анги-ойн мэргэжлийн байгууллага - ойн нөхөрлөл гэсэн бүтцийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд ойд гарах түймрийн тоо, нэрвэгдэх талбайн хэмжээ жилээс жилд буурч байна.

1.2. Ойн хөнөөлт шавж, өвчний судалгаа, тэмцлийн ажил.

Ойн хөнөөлт шавж өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажилд дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, химийн бодисын хэрэглээнээс үе шаттайгаар татгалзаж, биологийн арга, технологид бүрэн шилжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Ойн хөнөөлт шавж өвчний тархалтыг тогтоох судалгааны ажлыг 2015 онд 16 аймгийн 97 сумын 2009.0 мян.га талбайд хийж гүйцэтгэсэн. Судалгаагаар ойн хөнөөлт шавжийн тархалттай 14 аймгийн 73 сумын ойн сангийн 586.6 мян.га талбайгаас 310.3 мян.га талбайд зайлшгүй тэмцлийн ажил явуулах шаардлагатай талбай байгааг тогтоосон. Ойн хөнөөлт шавжийн тархалтыг хязгаарлах, тоо толгойн нягтшилтыг бууруулах тэмцлийн ажлыг 163.9 мян.га талбайд хийсэн нь нийт тэмцэл хийх шаардлагатай талбайн 52.8 хувьтай тэнцэж байна.

Ойн хөнөөлт шавж өвчний тархалтыг тогтоох судалгааны ажлыг 2016 онд 16 аймгийн 107 сумын 2607.4 мян.га, талбайд явуулж 591.1 мян.га талбайд хөнөөлийн голомт байгааг тогтоолоо. Үүнээс голомтыг устгах тэмцлийн ажлыг улсын төсвийн хөрөнгөөр 4 аймгийн 19 сумын ойд 70.8 мянган га талбайд, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 65.0 мян.га талбайд явуулсан нь нийт тэмцэл хийх шаардлагатай талбайн 21.9 хувьтай тэнцэж байна.

Ойн хөнөөлт шавж өвчнөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах эрх зүйн орчинг сайжруулах чиглэлд анхаарч 7 стандартыг боловсруулж, батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.

Улсын төсвийн хөрөнгөөр ойн хөнөөлт шавжийн судалгаа, тэмцлийн ажил явуулсан талбайн хэмжээ, 2015-2016 он /мян.га/




Хөнөөлийн голомт бүхий талбай өмнөх жилүүдээс өсөж гарсан нь 2015 онд хөнөөл учруулж байсан Якобсоны төөлүүрч эрвээхэйн хөнөөлийн голомт тэмцлийн ажлын үр дүнд буурч байгаа хэдий ч Булган, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул аймаг болон нийслэлийн ногоон бүсийн ойн санд өрөөсгөл хүр эрвээхэйн хөнөөлийн голомт шинээр 249.6 мян.га-д илэрсний улмаас хөнөөлийн голомт бүхий талбайн хэмжээ өссөн үзүүлэлттэй гарсан. Сүүлийн жилүүдэд санхүүжилтийн хүндрэлээс шалтгаалж тэмцэл хийх зайлшгүй шаардлагатай талбайг бүрэн хамруулж хийгээгүйс хөнөөлийн голомтыг бүрэн хязгаарлаж чадахгүй байна.

Цаашид улсын төсвийн хөрөнгөөр бүс нутгийг дамжин их хэмжээний ойг хамарсан хөнөөлийн голомтыг авиа микробиологийн аргаар, бусад тохиолдолд орон нутаг жил бүр төсөвтөө ойн хөнөөлт шавжийн голомтыг хязгаарлах зардлыг тусгаж, байгаль орчинд сөрөг нөлөөгүй орчин үеийн дэвшилтэт технологи, энгийн механик, физик, биологийн аргуудыг ашиглаж тэмцлийн ажлыг зохион байгуулж байх бодлого барьж ажиллана.

Иймд Орон нутаг Ойн тухай хуулийн 27.1-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга ойг хөнөөлт шавж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэдгээртэй тэмцэх хөтөлбөр боловсруулж, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүр орон нутгийн төсөвт тусгуулах арга хэмжээ авна”, мөн “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”-ийн 18.1-д “Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос 85 хувийг ойг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах шаардлага байна.

1.3. Хууль бус мод бэлтгэл. Манай улсын ойд гарсан зөрчлийн судалгаанаас харахад ойн нөөцийг хомсдуулагч нэг хүчин зүйл нь хууль бус мод бэлтгэл байна/зураг 4/.


Зураг 4



Хууль бус мод бэлтгэлийн талаар бүртгэгдсэн хэрэг зөрчлийн тоо 2012 онд 867 байсан бол 2016 онд 288 болж 67 хувиар, захиргааны арга хэмжээ авсан зөрчлийн тоо 2012 онд 538 байсан бол 2016 онд 262 болж 51,3 хувиар, хууль бусаар бэлтгэгдэж хураагдан улсын орлого болсон мод, модон материалын хэмжээ 2012 онд 7,6 мянган шоометр байсан бол 2016 онд 2,9 мянган шоометр болж 61,8 хувиар тус тус буурсан байна /МХЕГ, БОГУУХГ-ын мэдээллээр/.

Зураг 5.

Ойн тухай хууль тогтоомжийн талаар гарсан хэрэг зөрчлийн тоо



Цаашид дараах арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Үүнд:

- Мод, модон материалын эрэлт нийлэлтийн оновчтой арга хэмжээг авах, хууль зүйн хариуцлагыг чангатгах, иргэдийн оролцоог урамшуулах зэрэг арга механизмыг хэрэглэх замаар хууль бус мод бэлтгэлийг таслан зогсоох.

- Ойн тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан 2017 онд багтаан БОАЖСайд, Сангийн сайдын хамтарсан урамшуулалын журам боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангуулах,

- “Ойн цэвэрлэгээ” хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулж, түлшний модны хангамжийг сайжруулах, ойн нөөц бүхий сумдад модны нэгдсэн захууд байгуулах ажлыг зохион байгуулах,

- Сум, суурин газрын сургууль, цэцэрлэг, эмнэлэг, захиргааны байрыг нэгдсэн халаалтанд шилжүүлэх замаар түлшний модны хэрэглээг бууруулах ажлыг дэмжих .

Монгол орны ойг хомсдол, доройтлоос сэргийлэх асуудлаар НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр болон ХХААБ-н санхүүгийн дэмжлэгтэйгээр Монгол орны UN-REDD Үндэсний Хөтөлбөрийг 2015 оны 09-р сараас эхлэн 3-н жилийн хугацаатайгаар хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөр нь Монгол орны ойн доройтол, хомсдолд хүчин зүйлсийг тодорхойлох, тэдгээрт чиглэсэн бодлого, арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх зорилготойгоор БОАЖЯ-ны Ойн бодлого, зохицуулалтын газартай дараах 4 чиглэлээр хамтран ажиллаж байна. Үүнд:

1. Монгол орны UN-REDD Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаанд ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах бодлого, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө бүхий REDD+-ийн Үндэсний Стратегийг холбогдох талуудын оролцоотойгоор боловсруулж байна.

2. Үндэсний Ойн Мониторингийн систем (YOMC)-ийг бүрдүүлэх, бий болгох ажлыг тус хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр хийх саналыг тавиад байна.

3. Ойн Суурь Түвшин (ОСТ) тооцоход хэрэглэгдэх түүхэн хугацааны газар ашиглалтын өөрчлөлтийн мэдээг хиймэл дагуулын мэдээнд үндэслэн үнэлснээр анхан шатны үйл ажиллагааны мэдээ (YAM) -г боловсруулж, нарийвчлалыг үнэлж байна. ОСТ-г боловсруулах

чадавх бэхжүүлэх үйл ажиллагааны хүрээнд төрийн байгууллага, судалгааны хүрээлэн болон бусад оролцогч талуудын мэргэжилтнүүдэд Техникийн Ажлын Хэсгийн уулзалтууд, бусад сургалт семинаруудыг зохион байгуулав. Ойн суурь түвшинг тодорхойлох ажлыг 2018 онд бэлэн болгоно.

4. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх мэдээллийн систем оролцох талуудыг урьдчилсан байдлаар тодорхойлсон. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх мэдээллийн системийн суурь тавих үндсэн ажлуудыг 2017-2018 онд хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна.

2. Ойг нөхөн сэргээх, ойжуулах, тарьц, суулгац ургуулах, сор шилмэл модны сайн чанарын үр бэлтгэх хэмжээг нэмэгдүүлэн, арга технологийг сайжруулж, бодит хүчин чадлыг бий болгох замаар ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлэх:

2.1. Ой нөхөн сэргээлт, ойжуулалт: Улсын хэмжээгээр 2015 онд 5717.7 га талбайд, 2016 онд 3435.0 га талбайд нийт 9152.7 ойг нөхөн сэргээх ажлыг зохион байгуулснаас ойжуулалтын ажлыг 8401.0 га, ойн зурвасыг 523.7 га, байгалийн сэргэн ургалтанд туслах ажлыг 185.0 га, Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “4 зүг 8 зовхис” төслийн хүрээнд авто замын хамгаалалтын ойн зурвас 43 га талбайд тус тус гүйцэтгэсэн.


Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 2010 оны 63, “Хот орчныг цэцэрлэгжүүлэх тухай” 2013 оны 178 дугаар зарлигийн хэрэгжилтийг хангах зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг хавар, намрын мод тарих ажлын хүрээнд улсын хэмжээнд 2015 онд “Нэг сая мод ургуулах хөдөлгөөн”-ийг өрнүүлж 1796986 ширхэг төрөл бүрийн мод, сөөгийг 227244 иргэд, 11048 аж ахуй нэгж, байгууллага тарьж, шинээр 201 бичил цэцэрлэгийг байгуулж тохижуулсан бол 2016 онд 5154 иргэд, 97739 аж ахуй нэгж, байгууллага 689385 ширхэг мод, сөөгийг тарьсан (Хүснэгт 2, зураг 6).

Хүснэгт 2

2015-2016 оны ойн нөхөн сэргээх ажил


Арга хэмжээ		2015 он	2016 он
Үрийн аж ахуй	үр бэлтгэх талбай, га	50	25
	үрийн модонд	612	477
Ургуулсан тарьц, суулгац, сор шир		46.3	30,0
Ой нөхөн сэргээлт	ойжуулалт /га/	5240	3163
	ойн зурвас /га/	392,7	172
	БСУГ	85	100
	Нийт	5717,7	3435,0

2015 онд гүйцэтгэсэн ойжуулалт, ойн зурвасын талбайн хэмжээ /га-аар/



Зураг 7

2016 онд гүйцэтгэсэн ойжуулалт, ойн зурвасын талбайн хэмжээ /га-аар/



2.2. Ойн үрийн аж ахуй, мод үржүүлэг, тарьц, суулгац ургуулах ажил:

Ойн тогтвортой менежментийг сайжруулах тулгуур суурь асуудал нь модны үрийн чанарыг сайжруулах, удамших чанарыг хадгалах явдал юм. Шилмэл модны үр бэлтгэх, ойн үрийн байнгын болон түр талбайг байгуулах ажлыг нэмэгдүүлэх, байгуулсан талбайн арчилгаа хамгаалалтыг сайжруулах, сайн чанарын тарьц ургуулах зэрэг арга хэмжээг авч

хэрэгжүүлж байна. Тухайлбал, Орон нутгийн ойн генийн санг хөгжүүлэхэд болон экологийн хувьд тэнцвэртэй ойн бүлгэмдлийг нөхөн сэргээхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор БНЧУ-ын ойн мэргэжилтэн нартай хамтран ажиллаж байна. 2015-2016 онд ойн сан бүхий аймгуудад нийт 25га талбай үрийн байнгын талбай тусгаарах, 2017 онд 20 га талбайд үрийн байнгын талбай байгуулах ажлыг Сум дундын ойн ангиуд гүйцэтгэж байна. 2017 онд Хэнтий аймгийн Биндэр суманд шилмэл шилмүүст модны үрийн плантаци байгуулах, Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт үйлдвэрлэлийн зориулалт бүхий өндөр бүтээмжтэй мод үржүүлгийн аж ахуй эрхлэх ажлыг 5 га талбайд тус тус эхлүүлээд байна. Үрийн ургац сайн жилд дунджаар 400 кг үр түүж бэлтгэн, улсын үрийн нөөцийн санд хадгалав.

2015-2016 оны байдлаар, улсын хэмжээнд нийт 311 мод үржүүлгийн газарт 48,0 сая ширхэг тарьц, суулгац ургуулсан байна. “ОСХТ” УТҮГ-ын Дамбадаржаа дахь модлог ургамлын цуглуулгын цэцэрлэгт жилд дунджаар 100,0 мян доошгүй бортого үйлдвэрлэх хүчин чадал бүхий цехийг ашиглалтанд оруулж, бортоготой тарьц ургуулахад шаардлагатай хиймэл хөрс үйлдвэрлэх ажлыг эхэлж байна. Цаашид зураг, төсвийн дагуу ойжуулалт, ойг нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэх, үр, тарьц суулгац, ойжуулалт, ойг нөхөн сэргээх асуудлыг цогцоор нь авч үзэж шийдвэрлэх, санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх, эдийн засгийн хөшүүрэг хэрэглэх, техник, технологийг шинэчлэх, инноваци нэвтрүүлэх, ойжуулалт, ойг нөхөн сэргээх ажлын бүтэц, зохион байгуулалт, менежментийг сайжруулах, бортоготой тарьцаар ойжуулалт хийх аргад шилжих, тарьсны дараах арчлалт, хамгаалалтын асуудлыг шийдэх, зардлын нормативыг бодитойгоор тооцож нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөж байна.

3. Ойн тогтвортой менежментийг бий болгон ойгоос гарах бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж, экологийн болон эдийн засаг, нийгмийн үр ашгийг сайжруулах:

3.1. Ойн нөөцийн төлөв байдал. Монгол орны ойн нөөц 1 245 374 410 шоо метр байна. Ойн нөөцийн 78.5% шинэс, 4.9% нарс, 9.4% хуш, 0.23% гацуур, 0.02% жодоо, 6.17% хус, 0.18% улиас, 0.05% улиангар, 0.007% хайлаас, 0.27% бургас, 0.002% тоорой, 0.14%-ийг заган ойн нөөц тус тус эзэлж байна.

Хүснэгт 3

Ойн нөөц модны төрлөөр /шоо метр/

Модны төрөл	2015 он	2016
Шинэс	977314580	978126270
Нарс	61857540	62073010
Хуш	116121510	116993720
Гацуур	2861680	2838480
Жодоо	238800	238800
Хус	76830290	76870600
Улиас	2178620	2235900
Улиангар	677530	674280
Хайлаас	81110	81110
Бургас	3430670	3408260
Заг	1808250	1 808 250
Тоорой	25730	25730
Нийт дүн	1243426310	1243150807

*Эх үүсвэр: Ойн судалгаа, хөгжлийн төв

Монгол орны ойн шилмүүст модны дундаж нас 133 жил, навчит үүлдрийн модны дундаж нас 46 жил, 1 га талбайн нөөц шилмүүст ойнх 151.3 шоо метр, навчит ойнх 46.3 шоо метр, 1 га талбайн өсөлт шилмүүст үүлдрийн ойд 1.13 шоо метр, навчит үүлдрийн ойд 0.98 шоо метр, жилийн бүх дундаж өсөлт 10.063.255 шоо метр байна.

Ойн сангийн талбай, өөрчлөлт. 2016 оны байдлаар Монгол улсын ойн сан бүхий газар 18459.1 мян.га буюу нийт нутаг дэвсгэрийн 11.8 хувийг эзэлнэ. Үүнээс ойгоор бүрхэгдсэн талбай 12290.4 мян.га буюу ойрхог чанар (Ойгоор бүрхэгдсэн талбайг нийт газар нутагт харьцуулсан хувь) 7.9% байна (Хүснэг 4). Монгол орны ойг хамгаалалт, ашиглалтын хэлбэр, экологи-эдийн засгийн ач холбогдлыг нь харгалзан хамгаалалтын, ашиглалтын гэсэн 2 бүсэд хуваах бөгөөд хамгаалалтын бүсийн ойд нийт ойн сангийн 79.5% буюу 14 681 244 га, ашиглалтын бүсийн ойд 20.5% буюу 3 777 801 га талбай тус тус хамаарна. Өнөөгийн байдлаар 1836.5 мян.га талбайг ойн түймэр болон хөнөөлт шавжид нэрвэгдэж дахин сэргэн ургах чадваргүй болсон ой, 106.7 мян.га талбайг мод бэлтгэсэн, 0.9 мян.га талбайг байгалийн гамшиг гэнэтийн салхи шуурганд нэрвэгдсэн ойн талбай эзэлж байна.

Ойн сангийн талбайн өөрчлөлтийг 2014 оны байдалтай харьцуулахад ойгоор бүрхэгдсэн талбай 115.7 мян.га, ойгоор бүрхэгдээгүй талбай 22.2 мян.га-аар нэмэгдэж, ойн бус талбай 0.1 мян.га-аар буурч, нийт дүнгээрээ 137.8 мян.га талбайгаар нэмэгдэж ойрхог чанар 0.1 нэгжээр өсчээ.

Хүснэгт 4

Ойн сангийн талбай газрын төрлөөр

Үзүүлэлт		2015	2016
Нийт газар нутгийн хэмжээ		156411.6	156411.6
Ойн сангийн нийт талбай		18454.6	18459.1
Ойн талбай		17911.1	17915.7
Ойгоор бүрхэгдсэн		12280.0	12290.4
Үүнээс	Байгалийн ой	11500.4	11512.8
	Сөөг, торлог	777.5	775.5
	Таримал ой	2.1	2.1
Ойрхог чанар %		7.8	7.9
Ойгоор бүрхэгдээгүй		5631.1	5625.3
Үүнээс	Тармаг модод	3495.3	3497.0
	Түймэрт нэрвэгдсэн	1703.7	1701.4
	Мод бэлтгэсэн	106.1	106.7
	Байгалийн аясаар ойжиж байгаа	174.0	169.9
	Ойжуулсан	10.7	9.7
	Хөнөөлт шавжинд нэрвэгдсэн	135.8	135.1
	Салхи цасанд унасан ой	0.9	0.9
	Хатсан заг	4.6	4.6
Ойн бус талбай		543.5	543.4

*Эх үүсвэр: Ойн судалгаа, хөгжлийн төв

Ойн тооллого, ой зохион байгуулалт: Монгол орны ойн хүлэмжийн хийн шингээлт, ялгаруулалтын суурь үзүүлэлтийг тогтоох зорилгоор шилмүүст болон навчит ойг бүхэлд нь хамарсан олон улсын шаардлагад нийцсэн олон зорилтод ойн тооллогын ажлыг зохион байгуулав. Мөн Баянхонгор, Дундговь, Дорноговь, Өвөрхангай, Говь-Алтай аймгийн болон Улаанбаатар хотын ойн сангийн 1238.4 мян.га талбайд ой зохион байгуулалтын ажлыг гүйцэтгэж тухайн ажил явагдсан аймгуудын ойн сангийн ойн төлөв байдал, таксацийн

үзүүлэлтүүдийг шинэчлэн тогтоож, цаашид авах шаардлагатай ой аж ахуйн арга хэмжээг тусгасан тайлан, төсөл зураглалыг боловсруулан гаргав.

Олон зорилтод ойн тооллогоор Монгол орны ойн нийт ургаа нөөц 1.2 тэрбум.м³, босоо хатсан модны нөөц 172.0 сая.м³, унанги модны нөөц 248 сая.м³ байна гэж тогтоосон бөгөөд дараах гол дүгнэлтийг гаргаад байна. Үүнд:

Монгол орны ой бага ашиглагдсан байна: Ашиглалт болон хамгаалалтын бүсийн ойн үндсэн үзүүлэлтүүд хоорондоо ижил байна. Мөн 1 га талбайн ойн нийт нөөцийн 30%-ийг хатсан унасан модны нөөц эзэлж байна. Энэ нь 90-ээд оноос хойш баримталж ирсэн ойг зөвхөн хамгаалахад чиглэсэн бодлогын үр дагавар юм. 1970-аад онд жилд бэлтгэсэн модны хэмжээ 3.0 сая м³ байсан бол 2015-2016 оны дунджаар энэ тоо 691.5 мян.м³ байна.

Ойн нөөцийн дийлэнхийг болц гүйцсэн ойн нөөц эзэлж байна: Ойн нөөцийн ашиглалт бага байгаагаас үүдэн 1 га ойн ургаа нөөцийн 63%-ийг болц гүйцсэн, өсөлт удааширсан мод эзэлж байна. Болц гүйцсэн, өтөлсөн том мод нь биологийн төрөл зүйлийг хамгаалах ашиг тустай ч залуу модтой харьцуулахад өсөлт удаан, нүүрстөрөгчийг хуримтлуулах хэмжээ бага бөгөөд төрөл бүрийн хөнөөлт шавж, мөөгөнцөр өвчинд өртөмтгий байдаг.

1 га дахь ойн нөөц бага байна: Монгол орны ойн өтгөрлийн үзүүлэлт нь 0.48 байна. **Монгол орны ой эмзэг байна:** Олон төрлийн модноос бүрдсэн, титмийн олон давхрагатай ой нь өвчин, хөнөөлт шавжийн нөлөөнд тэсвэртэй байдаг. Монгол орны ойн талбайн 70%-д модны нэг төрөл зонхилсон дан бүрдэлтэй ой, 80%-д титмийн үе давхарга бага ой тус тус эзлэн ургаж байгаа нь ой эмзэг байгааг харуулна.

Ойн сэргэн ургах чадвар хангалттай байна: Монгол орны ойн 1 га талбайд 150 см-ээс дээш өндөртэй 959 өсвөр мод байгаа нь ой байгалийн аясаараа сэргэн ургах чадвар сайн байгааг илтгэнэ.

Ой, модны үйлдвэрлэл.

Одоо 21 аймаг, нийслэлд 450 гаруй аж ахуй нэгж байгууллага /+200 гаруй ХЭАА/, мод бэлтгэл, ойн цэвэрлэгээ, мод боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр 5,0 мянга орчим ажиллагсадтайгаар боловсруулах аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний 2-3 %-ийг үйлдвэрлэж байна. Статистик мэдээгээр сүүлийн 3 жилд жил бүр 14-18 тэрбум төгрөгийн, албан бус мэдээгээр 100 -110 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Үйлдвэрлэлийн чиглэлээр мод бэлтгэл, зүсмэл материал, модон бэлдэц, мебель тавилга, зөөлөн тавилга, модон байшин, барилгын модон хийц, гэрийн мод, хөгжмийн зэмсэг, модон тоглоом, бэлэг дурсгал, шахмал түлш зэрэг бүтээгдэхүүн гарч байна. Мод, модон материал, тавилгын 45 орчим хувийг дотооддоо 55 орчим хувийг импортоор авч, барилгын дотор хаалга, гал тогооны тавилгын 50-60 %-ийг дотоодын үйлдвэрүүд үйлдвэрлэж цаашид 100 % дотооддоо үйлдвэрлэх боломж бүрдэв. Энэ чиглэлээр цаашид дараах стратеги бодлогыг барь ажиллахаар төлөвлөж байна. Үүнд:

1. Монгол орны ойн онцлог, газар нутгийн нөхцөлд тохирсон, байгаль орчинд ээлтэй, экологийн тэнцвэрт байдлыг хадгалсан дэвшилтэт техник, арга, технологийн ойн нөөц баялгийг иж бүрэн, тогтвортой ашиглах үйлдвэрлэлийг дэмжиж, дотоодын нийт бүтээгдэхүүнд ойн салбарын эзлэх хувийг нэмэгдүүлэх;

2. Мод боловсруулах үйлдвэрүүдэд модыг гүнзгий боловсруулах орчин үеийн техник, технологийг нутагшуулж, модны ашиглалт, боловсруулалтын түвшинг дээшлүүлэх, ойн цэвэрлэгээгээр бэлтгэсэн модон түүхий эдийг боловсруулж шинэ нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж ойгоос бэлтгэсэн 1 шоо метр модны ашиглалтыг 2020 онд 80,0 хувьд, 2030 онд 90,0 хувьд хүргэх;

3. Модон материалын импортыг нэмэгдүүлж, импортын модоор наамал дүнг, цул модон хавтан, тавилга, монгол гэр зэрэг зарим нэрийн модон бүтээгдэхүүнийг экспортлох;

4. Ашиглалтын ойн нөөц бүхий бүс нутагт ойн төв зам барьж байгуулах;

5. Ойн цэвэрлэгээ хөтөлбөрийг хэрэгжүүлж ойн хоёрдогч түүхий эдээр төрөл бүрийн

шахмал хавтан /МДФ, ДСП, WPC/, шахмал түлш болон барилгын модон материал үйлдвэрлэж, ойн хаягдлыг эдийн засгийн эргэлтэнд оруулах;

4. Ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх:

4.1. Ойн сангийн ашиглалт: Төрөөс ойн талаар баримтлах бодлогын баримт бичигт заасан мод, модон материалын эрэлт нийлүүлэлтийн оновчтой арга хэмжээг авах зорилтын хүрээнд Ойн тухай хуульд заасны дагуу аймаг, нийслэлийн Засаг даргын санал, ой зохион байгуулалтын баримт бичиг, ойн менежментийн төлөвлөгөөг үндэслэн улсын хэмжээнд ойгоос тухайн жилд бэлтгэх модны дээд хязгаарыг баталсан шийдвэр гарган ажиллаж байна. Улсын хэмжээнд 2015-2016 онд ойгоос бэлтгэх модны дээд хязгаарыг 2.1-1.4 сая.м³-ээр тогтоосон хэдий ч гүйцэтгэлээс үзэхэд жилд дунджаар 691.5 мян.м³ мод бэлтгэж ашиглан, 2.7 тэрбум төгрөгийн орлого орон нутгийн төсөвт оруулжээ. Жилд бэлтгэж байгаа модны хэмжээг огтлолтын төрлөөр авч үзвэл 6.0%-ийг үйлдвэрлэлийн, 3.9%-ийг арчилгааны, 90.0%-ийг цэвэрлэгээний огтлолтоор бэлтгэж үүний 24.1%-ийг үйлдвэрлэлийн болон ахуйн хэрэглээний мод, 75.9%-ийг түлээний мод эзэлж байна.

Хүснэгт 5.

Ойгоос бэлтгэсэн модны хэмжээ, орон нутгийн төсөвт орсон орлого

д/д	Он	Нийт бэлтгэсэн модны хэмжээ /м ³ /	Үүнээс			Ойгоос мод бэлтгэсний төлбөрийн орлого /мян.төг/
			Үйлдвэрлэлийн огтлол тоор /м ³ /	Арчилгааны огтлолтоор /м ³ /	Цэвэрлэгээний огтлолт, цэвэрлэгээний ажлаар /м ³ /	
1	2015	651984	29847	22458	599679	2665.3
2	2016	731046	30796	28128	672122	2750.1
	ДҮН	1383030,0	60643,0	50586	1271801	5415,4

Сүүлийн 8 жил буюу 2009-2016 онд 503.8-843,9 мян.м³ буюу жилд дунджаар 730,8 мян.м³ мод бэлтгэн, мод, модон материал, түлшний хэрэгцээг хангаж байна. Үүнийг огтлолтын төрлөөр авч үзвэл жилд дунджаар 6.9% буюу 50,2 мян.м³ модыг үйлдвэрлэлийн ашиглалтаар, 4,2% буюу 30,8 мян.м³ модыг арчилгааны огтлолтоор, 88,8% буюу 643,8 мян.м³ модыг цэвэрлэгээний огтлолт болон цэвэрлэгээний ажлаар бэлтгэсэн байна.

Хүснэгт 6

Сибирь хуш(Pinus sibirica Du Tour.) модны самрын бэлтгэл

№	Самрын ашиглалтын зориулалт	Түүж бэлтгэсэн хэмжээ, /тн/						Нийт	
		2014		2015		2016		Хэмжээ /тн/	Төсөвт орсон орлого /мян.төг/
		Хэмжээ /тн./	Төсөвт орсон орлого /мян.төг/	Хэмжээ /тн./	Төсөвт орсон орлого /мян.төг/	Хэмжээ /тн./	Төсөвт орсон орлого /мян.төг/		
1	Үйлдвэрлэлийн	648.7	555514.5	4740.1	3816293.3			5388.8	4371807.8
2	Ахуйн	9.8	4910.0	70.5	35256.5			80.3	40166.5
	Нийт дүн	658.5	560424.5	4810.6	3851549.8	7886.5	6156244.5	13355.6	10568218.8

Ойн цэвэрлэгээ хөтөлбөрийн хүрээнд 2015-2016 онд Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Төв аймгийн 10 сумдын ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагын ажилчдад мэргэжилтэй ажилтан бэлтгэх түр сургалтыг зохион байгуулж 343 хүнийг хамруулав. Мөн ойн цэвэрлэгээнд ашиглах техник, тоног төхөөрөмжийг сурталчилан танилцуулах, үзүүлэх сургалтыг Сэлэнгэ аймгийн Мандал сумын Түнхэл, Төв аймгийн Мөнгөнморьт суманд зохион байгуулж хөтөлбөр эхний ээлжинд хэрэгжих 2 аймгийн болон 5 сумын удирдлагууд, ойн нөхөрлөл, мэргэжлийн байгууллагын ажилчдыг хамруулж үзүүлэх сургалтыг зохион байгуулсан. 2016 онд 7 аймгийн 42 сумын 101 ААНБайгууллага, 126 ойн нөхөрлөлийн 1454 иргэн хөтөлбөрт хамрагдан 377 иргэн түр болон байнгын ажлын байраар хангагдан ажилласан байна.

5. Ойн эрхзүйн орчныг сайжруулан “ойн сайн засаглал”-ыг бий болгож, салбарын шинжлэх ухаан, сургалт, боловсрол, мэдээлэл, сурталчилгааг эрчимжүүлэх:

5.1. Ойн санг гэрээгээр эзэмшиж буй нөхөрлөлийн үйл ажиллагаа. 2009 онд Засгийн газраас “Ойн санг гэрээгээр эзэмшүүлэх журам”-ыг баталж, 2012 онд Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар хамтын оролцоонд түшиглэсэн ойн менежментийг хөгжүүлэх чиглэлээр заалтууд шинээр тусгагдсанаар ойн сангийн тодорхой хэсгийг ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгуулагад гэрээгээр эзэмшүүлэх эрх зүйн орчин бүрдсэн.

2016 оны байдлаар, 1281 ойн нөхөрлөл 23496 гишүүнтэй 6742 өрх улсын эмжээнд 3.345.434,5 га талбай бүхий ойн сан эзэмшиж байна (Хүснэгт-7).

Хүснэгт 7


Ойн нөхөрлөл, тэдгээрийн гэрээгээр эзэмшиж буй ойн сангийн хэмжээ

Үзүүлэлт	2015 он	2016 он
Нөхөрлөлийн тоо	1218	1281
Эзэмшиж буй ойн сан /га/	3.169.478,6	3.345.434,5

Нийт 1281 нөхөрлөлөөс 857 нөхөрлөлийн ойн санд ой зохион байгуулалтын ажил хийгдэж, 628 нөхөрлөл ойн менежментийн төлөвлөгөөгөө батлуулсан, 720 нөхөрлөл нь гэрчилгээтэй байна. Нутгийн иргэд нөхөрлөл байгуулж ойн санг гэрээгээр эзэмших хүсэл сонирхол нэмэгдэж байгаа ч төрийн өмчийн ойг гэрээгээр эзэмшиж хамгаалсны төлөө олгох урамгшуулал байдаггүйгээс зарим нь гэрээгээ цуцлах, зарим нь гаргасан зардлаа нөхөхийн тулд элдэв хууль бус үйл ажиллагаа явуулах байдал гарч болзошгүй хандлага ажиглагдаж байна. Иймд нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлагатай.

Зураг 8

Ойн санг нөхөрлөлд эзэмшүүлсэн байдал



Ойн мэргэжлийн байгууллага: 2015 онд 692 аж ахуйн нэгж 883 чиглэлээр ойн мэргэжлийн байгууллагын эрх аван үйл ажиллагаа явуулж байсан бол 2016 оны байдлаар 814 аж ахуйн нэгж 1032 чиглэлээр ойн мэргэжлийн байгууллагын эрх аван үйл ажиллагаа явуулж байна (Хүснэгт-8).

Хүснэгт 8

Ойн мэргэжлийн байгууллагын эрх авсан аж ахуйн нэгж байгууллагын тоо, чиглэл

д/д	Үйл ажиллагааны чиглэл	2015	2016
1	Ойн сангийн тооллого бүртгэл, ой зохион байгуулалт	19	22
2	Ойн хөнөөлт шавьж өвчнөөс хамгаалах, тэдгээртэй тэмцэх	27	31
3	Ойд үйлдвэрлэлийн ашиглалт явуулах	44	53
4	Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх	358	400
5	Ойн дагалт баялаг ашиглах	62	95
6	Ойг нөхөн сэргээх, ойжуулах, мод үржүүлэх	373	431
	ДҮН	883	1032

5.2. Салбарын шинжлэх ухаан, сургалт, боловсрол.

Төрөөс ойн талаар баримтлах бодлогын 5 дахь зорилтот дэвшүүлсэн шинжлэх ухаан, сургалт, боловсролын хүрээнд дараах ажлуудыг эхлүүлээд байна.

“Монгол орны ойн бүтээмж, хөдлөлзүй”-гэсэн суурь судалгааны сэдэвт ажлын хүрээнд 2015-2016 онд Сэлэнгэ, Төв, Хөвсгөл, Архангай, Булган аймгийн ой бүхий нутагт хээрийн судалгаа хийж, ойн түймэр, хөнөөлт шавьж дээрхи нутгийн ойн экосистемийн доройтол, хомсдолд хамгийн их сөрөг нөлөө үзүүлж байгаа хүчин зүйл болохыг тогтоож, түймрийн тархалт, хөнөөлт шавьжийн олшролтоос сэргийлэх, тэдгээртэй тэмцэх, ойн доройтолд орсон талбайг нөхөн сэргээх талаар дүгнэлт, зөвлөмж гаргасан байна.

Монгол орны голлох шилмүүст, навчит модны газрын дээрхи биомассыг тодорхойлох тэгшитгэл зохиож, улсын ойн нийт биомасс, нүүрстөрөгчийн нөөц, нүүрсхүчлийн хийн шингээлтийг урьдчилсан байдлаар тооцоолж гаргав. Цаашид энэ ажлыг үргэлжлүүлэн хийж, 1 га талбайн нөөцийг биомасст шилжүүлэх коэффициент, үндсэн төрлийн модны суурь нягт зэрэг ойн хүлэмжийн хийн тооллого хийхэд шаардлагатай жишиг үзүүлэлтийг улсын хэмжээнд тогтоох судалгааны ажил хийх шаардлагатай.

Завхан аймгийн Булнай суманд 1979 онд анх хийсэн ойн арчилгааны огтлолтын туршилтын талбайд явуулж байгаа олон жилийн мониторингийн судалгааг 2016 онд үргэлжлүүлэн хийж Төв Хангайн залуу шинэсэн ойд арчилгааны огтлолт хийх хамгийн тохиромжтой эрчим, технологийн үзүүлэлтийг тогтоосон нь Монгол орны ойн өсөлт, бүтээмж, нүүрстөрөгчийн нөөц, шингээлтийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой болжээ.

Ойн салбарын сургалт, боловсролын чиглэлээр МУИС, ХААИС, ШУТИС зэрэг их, дээд сургуулиудын материалаг суурь дээр түшиглэн сургалт-үйлдвэрлэлийн дараах лаборатори, төвүүдийг байгуулан хамтран ажиллаж байна. Үүнд:

- Дендрохронологийн лаборатори
- Ойн экосистемийн мониторингийн лаборатори
- Ойн генетик, эко-физиологийн лаборатори
- Төв Азийн бүсийн түймрийн менежментийн төв
- Төв аймгийн Батсүмбэр дэх “МУИС-ийн Ойн сургалт, судалгааны төв”,
- Төв аймгийн Баянчандмань дахь “ХААИС-ийн мод үржүүлгийн сургалт-судалгаа-үйлдвэрлэлийн төв”.
- Сэлэнгэ аймгийн Мандал суман дахь “ШУТИС-ийн Ой, модны сургалт, судалгааны хүрээлэнгийн Ойжуулалт, мод үржүүлэг, ойн мөхникжуулалтын хээрийн сургалтын полигон”.

"Монгол орны ойн мэргэжлийн боловсролын байдал" сэдэвт үндэсний хурлыг 2015 оны 12-р сарын 4-нд МУИС, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран зохион байгуулж, ойн салбарын дээд боловсролын сургалт эрхлэн явуулдаг МУИС-

ийн ХШУИС-ийн Хүрээлэн буй орчин, ойн инженерчлэлийн тэнхим, ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн Ой модны үйлдвэрлэлийн технологийн салбар, ХААИС-ийн Агроэкологийн сургуулийн Экологийн тэнхим, ХААИС-ийн Дархан хот дахь салбар сургуулийн багш, судлаачид оролцлоо. Монгол орны ойн салбарын сургалтын ирээдүй, сургуулиудын хамтын ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор дээрх сургуулиуд "Хамтын ажиллагааны гэрээ" байгуулав.

- МУИС-ын Ойн сургалт судалгааны төвийн эзэмшлийн ой бүхий газар ойн нүүрстөрөгчийн тэнцвэрт байдал, гидро цаг уурын ажиглалт, фенологийн ажиглалт хийх зориулалтын камер, хэмжилтийн автомат сенсор бүхий 25м өндөртэй цамхагийг Монгол орны мөнх цэвдэг бүхий хөрсөнд ургаж байгаа шилмүүст ойг төлөөлүүлэн сонгон авч урт хугацааны мониторинг хийх зорилгоор ажиллуулж эхэллээ. Энэхүү цамхаг нь Зүүн хойд Азийн ойн экосистемийн мониторингийн сүлжээ цамхагуудын нэг юм.

- "Чацарганы плантаци –Тайтгарлын Ой байгуулах Хамтарсан төсөл", Малын бэлчээрийг сэргээх, цөлжилтийг сааруулах, нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд ажлын байр бий болгох, Засгийн газар, их сургууль, төрийн бус байгууллага болон иргэдийн хамтын ажиллагааг тэлж хүрээлэн буй орчны асуудлыг шийдэх зорилгоор БНСУ-ын Донгукын Их Сургуультай хамтарсан төслийг хэрэгжүүлж, нийт 4,5 га талбайд Чацарганы (*Hipporhamnoides L.*) плантацийг байгуулав.

- МУИС, Солонгосын Үндэсний Арборетумын хамтарсан "Ой ургамалжилтын уур амьсгалын өөрчлөлтөнд үзүүлэх хариу үйлчлэлийн урт хугацааны мониторинг судалгаа" Ойн экосистем, түүний бүрэлдэхүүн хэсгүүд болох модлог ургамал, өвслөг ургамлын бүрхэвч, түүнд гарч буй өөрчлөлтийг урт хугацаанд мониторинг судалгаа хийх, ургамлын бүрхэвчийн өөрчлөлт, цаг уурын өөрчлөлтөнд үзүүлж буй хариу үйлчлэлийг судлан илрүүлэх зорилгоор судалгааын ажлыг эхлүүлээд байна.

- МУИС, Финляндын Ойн хүрээлэнгийн судлаачид хамтран "StreForMon" төслийн хүрээнд Ойн байгалийн сэргэн ургалтыг дэмжих олон хувилбарт туршилт судалгааны 8 ширхэг байнгын дээж талбайг байгуулан, удаан хугацааны мониторинг судалгаа хийж эхлэв.

- "ОЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ТӨВ" УТУГазартай хамтран тарьц суулгацыг хамгаалалтай хөрс, бортогонд ургуулах, бортоготой тарьцанд зориулсан хиймэл хөрсний холимог бэлтгэх туршилтын ажлыг хийж байна.

- "Төв Азийн бүс нутгийн түймрийн менежментийн сургалт"-ыг 2015 оны 9-р сард МУИС-ын Ойн сургалт судалгааны төвд зохион байгуулав. Тус сургалтанд Герман, Казахстан, Узбекистан, Киргизстан зэрэг орнуудын байгалийн түймрийн мэргэжилтнүүд, Төв аймгийн Онцгой байдлын албаны бие бүрэлдэхүүн, Батсүмбэр сумын Ойн анги, байгаль хамгаалагчид, нутгийн иргэдийн төлөөлөл оролцов. Сургалтыг Дэлхийн түймрийн мониторингийн төвтэй хамтран Европын Аюулгүй Байдал Хамтын Ажиллагааны Байгууллага (ЕАБХАБ)-ын санхүүжилтээр МУИС-д хэрэгжүүлж буй "Монгол орон ба Төв Азийн зарим орнуудын түймрийн менежментийн чадавхийг сайжруулах нь" сэдэвт төслийн хүрээнд зохион байгууллаа. Тус сургалтаар Европын түймрийн стандарт, түймэр унтраах багаж хэрэгслийг хэрхэн зөв, үр дүнтэй хэрэглэх, өвслөг болон модлог ургамлан шатах материалыг хяналттайгаар (зориудаар) шатааж багасган, ирээдүйд гамшгийн хэмжээний томоохон түймэр гарах эрсдлийг бууруулах туршилт, үзүүлэх сургалтыг хийж харуулсан нь чухал ач холбогдолтой боллоо.

5.3. Ойн салбарын гадаад хамтын ажиллагаа. Монгол орны ойн салбарт гадаадын төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилтээр дараах төслүүдийг хэрэгжүүлж байна.

- ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны санхүүжилтээр "Биологийн олон янз байдал ба уур амьсгалын өөрчлөлтөд ойн гол экосистемүүдийн дасан зохицох нь II" хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Энэ төслийн хүрээнд Экологийн ач холбогдол бүхий тодорхой газар нутагт (ойн гол экосистемүүд) уур амьсгалын өөрчлөлтийг харгалзсан

тогтвортой менежмент болон хамгааллын арга хэмжээг авч хэрэгжүүлэн биологийн олон янз байдлыг хамгаалах, орон нутгийн хүн амын амьжиргааны нөхцөлийг сайжруулах зорилготойгоор ажилллаж байна.

- ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны санхүүжилтээр “REDD+д нийцсэн Монгол Улсын Үндэсний ОйнТооллого” төслийг Олон зорилтот үндэсний ойн тооллогын мэдээ баримтанд суурилсан уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицсон ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх зорилготойгоор хэрэгжүүлж байна.

- Бүгд Найрамдах Солонгос Улсын Ойн алба (KFS)-ны санхүүжилтээр Монгол-Солонгосын “Ногоон хэрэм” төслийг Шар шороон шуурга цөлжилтөөс хамаалах 3000 га талбайд ойн зурвас байгуулах зорилгоор хэрэгжүүлж, орон нутгийн БОАЖГ болон Ойн ангид хүлээлгэж өгөх үйл ажиллагаа явж байна.

- БНЧУ-ын Чехийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр "Монгол Улсын ойн сангийн экологийн төрөл зүйлийн генийн сангийн хөгжил" төслийг “Орон нутгийн ойн генийн санг хөгжүүлэхэд болон экологийн хувьд тэнцвэртэй ойн бүлгэмдлийг нөхөн сэргээхэд дэмжлэг үзүүлэх” зорилгоор хэрэгжүүлж эхлээд байна.

- Даян Дэлхийн Байгаль Орчны Сан /GEF/-ийн санхүүгийн дэмжлэгээр “Ой бүхий аймгуудын биологийн олон янз байдлын хамгаалал, тогтвортой ойн менежмент, нүүрстөрөгчийн хийн хуримтлалыг нэмэгдүүлэх” төслийг Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох замаар тогтвортой ойн менежмент нь биологийн олон янз байдал, газрын доройтлыг багасгах, нүүрстөрөгчийн хийн агууламжийг нэмэгдүүлэх, экосистемийн үйлчилгээ, ашиг тусын олон хэлбэрийг хангах зорилгоор хэрэгжүүлж байна.

- НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Байгаль орчны хөтөлбрийн санхүүжилтээр “Монгол орны UN-REDD Үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байна.

.....oOo.....